

СҮХБААТАР ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ХЯНАЛТ,
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН
ИЛТГЭХ ХУУДАС

Биеийн тамир, спортын хорооны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай

2025 оны 06 дугаар сарын 26

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Эрх зүйн үндэслэл нь Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам” -ын 2.1-д заасны дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны эхний хагас жилийн тайланд хяналт шинжилгээг хийж гүйцэтгэв.

Хяналт-шинжилгээний зорилго нь төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

ХОЁР. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААР ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хяналт-шинжилгээг хийхдээ Биеийн тамир, спортын хорооны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн тайлантай танилцах, тухайн ажлыг хариуцсан албан тушаалтантай уулзаж, ярилцаж, холбогдох бусад мэдээллийг ашиглан хийсэн.

Хүснэгт 1.

№	Бүлэг	Заалтын тоо
1	Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээ	14
2	Биеийн тамир, спортын бодлого хэрэгжилтийг хангах	4
3	Хуулиар олгогдсон чиг үүргийг хангах арга хэмжээ	4
Нийт		22

ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН

Биеийн тамир, спортын хорооны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн тайланг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам” -ын 2.4-т заасан аргачлалаар хяналт шинжилгээг хийсэн.

БОДЛОГО ТУС БУРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 2.

Д/д	Бодлогын нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжих хугацаа болоогүй	Дундаж үнэлгээ
1	Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээ	14	4	81%
2	Биеийн тамир, спортын бодлого хэрэгжилтийг хангах	4	1	83,3%
3	Хуулиар олгогдсон чиг үүргийг хангах арга хэмжээ	4		50%
Нийт		22	5	71,4%

АРГА ХЭМЖЭЭНИЙ ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 3.

Д/д	Бүгд	Үнэлгээ	2025 оны эхний хагас жил
Хэрэгжилт гаргах арга хэмжээний тоо			22
1	Бүрэн хангалттай	85% ба түүнээс дээш	8
2	Хангалттай	70-85% хүртэл	1
3	Хангалтгүй	70% хүртэл	8
Хэрэгжих хугацаа болоогүй			5
Хэрэгжилтийн дундаж			71,4%

Биеийн тамир, спортын хорооны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн тайланд хяналт-шинжилгээ хийхэд хэрэгжилтийн дундаж хувь 71,4%-тай байна. Нийт 22 заалтаас хэрэгжих хугацаа болоогүй 5 заалт, "Хангалтгүй" ангилалд 8 заалт, "Хангалттай" ангилалд 1заалт, "Бүрэн хангалттай" ангилалд 8 заалт тус тус байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. Биеийн тамир, спортын хорооны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн тайлан 71,4%-тай хэрэгжсэн байна.
2. Үнэлгээний аргачлалын дагуу нэгтгэн дүгнэхэд "Бүрэн хангалттай буюу 85-100%" гэж үнэлэгдсэн -8 арга хэмжээ, "Хангалттай буюу 70-84%" гэж үнэлэгдсэн 1 арга хэмжээ, "Хангалтгүй буюу 0-69%" гэж үнэлэгдсэн 8 арга хэмжээ байна.
3. Хэрэгжих хугацаа болоогүй 5 арга хэмжээ тус тус байна.

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Биеийн тамир, спортын хорооны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн тайланд хийсэн Хяналт-шинжилгээгээр дараах асуудлыг нийт албан хаагчдад анхааруулах шаардлатай байна. Үүнд:

1. Шинээр батлагдсан журамд нийцүүлэн төлөвлөгөөг шинэчлэх шаардлагатай байна.

- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол хүчингүй болж, 2025 оны 43 дугаар тогтоолоор шинэчилсэн журам мөрдөгдөж эхэлсэн.
- Иймд гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээ, шалгүүр үзүүлэлт, суурь ба зорилтот түвшин зэргийг шинэ журмын дагуу засварлах шаардлагатай.
- Арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшний уялдааг хангаж, төлөвлөлтийн алдаа тутагдлыг засаж, хэрэгжээгүй буюу хэрэгжилт хангалтгүй арга хэмжээг сүүлийн хагас жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг хангуулах.

2. Албан хэрэг хөтлөлт, үг үсэг, утга найрууллагын алдааг засаж сайжруулах

- Албан хэрэг хөтлөлтийн стандарт, үг үсэг, утга найрууллагын алдааг сайтар хянах, засах.


3. Тайлангийн шаардлага хангахгүй байгаа арга хэмжээнүүдэд сайжруулалт хийх.

4. Хариуцлагын асуудал

- Жилийн эцсийн биелэлтийг авахад дээрх алдаа зөрчил дахин давтагдвал тухайн ажил хариуцсан албан хаагчдад хариуцлага тооцуулах саналыг удирдлагад уламжлаж хэлэлцүүлэх тул тайлангийн биелэлтийн чанарт анхаарч ажиллана уу.

ТАНИЛЦСАН:

СҮХБААТАР БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ХОРООНЫ ДАРГА



Б.МӨНХ-ЭРДЭНЭ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

X. ИДЭР

Х.ИДЭР

СҮХБААТАР ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО

2025 оны 06 дугаар сарын 26

Улаанбаатар хот
Хүснэгт 5.

№	Агуулга	Бүгд	Бодлогын бичигт тусгагдсан арга хэмжээ	Биеийн спортын хэрэгжилтийг хангах	тамир, бодлого	Хуулиар олгогдсон чиг Уургийг хангах арга хэмжээ
	Нийт заалтын тоо	22		14	4	4
2	Бүрэн хангалттай	85% ба түүнээс дээш	8	6	2	
3	Хангалттай	70-84% хүртэл	1	1		
4	Хангалтгүй	70% хүртэл	8	3	1	4
5	Хугацаа болоогүй		5	4	1	
	Дундаж хувь	71,4%		81%	83,3%	50%